

СЭЛЭНГЭ АЙМГИЙН УЛСН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСЭЭС 2025 ОНД
ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН
ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ АЖИЛЛАСАН ТУХАЙ ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 01-ний өдөр

Сүхбаатар сум.

Үндэсний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, зөвлөмж, үүрэг чиглэлийн хэрэгжилтийг хангах тухай аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 02/1077дугаартай, албан бичгийг тус тус үндэслэн Монгол улсын ерөнхийлөгчийн 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 05 дугаар зарлигаар батлагдсан “Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын Улсын бүртгэлийн байгууллагад хамаарах заалтуудын дагуу 2025 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг хүргүүлж байна.

№	Хамаарах заалтууд	Зорилт болон суурь түвшин	Биелэлт
	2025 оны Аймаг нийслэл сум дүүргийн иргэдийн төлөөлөгчийн нөхөн сонгууль	Улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийн хувь	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдын хурлын нөхөн сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө, УБЕГ-ын ирүүлсэн чиглэлийн дагуу АНСДИТХ-ын нөхөн сонгуулийн “Нөхөн сонгууль товлон зарлах тухай” тогтоолыг 7 сумын ИТХ-аас хүлээн авч хяналт тавин 10 санал авах байр, хаягийн мэдээллийг шивж баталгаажуулан тогтоолын эх хувийг ИУБ-ийн газарт хүргүүлэв. Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/71 дугаартай “Иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох тухай” тушаалын дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

			Иргэний шилжин суурьших хөдөлгөөний бүртгэлийг зогсоохтой холбогдуулан заавар зөвлөмжийг нийт улсын бүртгэгч нарт хүргүүлэв. Шилжин суурьших хөдөлгөөний бүртгэл хийлгэснээс санал авах байранд бүртгэгдээгүй хаягийн жагсаалтад 25 хаяг, сонгогчдын нэрийн жагсаалтад хэсэг оноогдоогүй байсан 46 иргэнийг нэмж тухайн сонгуулийн хэсгийн хороонд бүртгэж баталгаажуулснаар АНСДИТХ-ын 2025 оны нөхөн сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалтад аймгийн хэмжээнд сонгуулийн насны 11905 иргэн бүртгэгдсэн байна. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй буюу буруу бүртгэгдсэн талаар гомдол мэдээлэл ирээгүй болно. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Сонгуулийн тухай хуулийг /нөхөн/ хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө Улсын бүртгэлийн Ерөнхий газрын Иргэний Улсын бүртгэлийн газраас ирүүлсэн чиглэл, Сэлэнгэ аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн даргын баталсан ажил үүргийн хуваарийн дагуу 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуулийн 16 дугаар тойргийн 10 хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтыг хэсэг тус бүрээр 2 хувь хэвлэв. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуулийн 16 дугаар тойргийн 10 хэсгийн хорооны сонгогчдын нэрийн жагсаалтыг нягтлан шалгаж 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр
--	--	--	---

			сонгогчдын нэрийн жагсаалт хүлээлцэх акт үйлдэн сонгуулийн хэсгийн хороодод хүргүүлээ. Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 25-ний өдрийн А/61 дугаарт “Иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох тухай” тушаалын дагуу 941 иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл хяналт тавин ажиллалаа. Шилжин суурьших хөдөлгөөний бүртгэл хийлгэснээс санал авах байранд бүртгэгдээгүй хаягийн жагсаалтад 235 хаяг, сонгогчдын нэрийн жагсаалтад хэсэг оноогдоогүй байсан 386 иргэнийг нэмж бүртгэж баталгаажуулжээ.
	Иргэний баримт бичгийг хуурамчаар үйлдэх, завсарлах, гадаад улсын иргэдэд ашиглуулах гэмт хэргийн талаар	Иргэний улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд засварласан бүртгэлийн тоо	Улсын бүртгэлийн Ерөнхий газрын нэгдсэн архивын газраас 9/4940 чиглэлээр ирүүлсэн төрсний бүртгэлийн 1951, гэрлэсний бүртгэлийн 1148, нас барсны 611 бүртгэлийг тасгийн улсын бүртгэгч нарт хувиарлан өгч шалгаж илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг авч төрсний 199, нас барсны 49, гэрлэсний бүртгэлийн 309 иргэний зөрчлийг арилгасан бөгөөд зөрчил арилгах арга хэмжээ үргэлжилж байна. Сумдын улсын бүртгэгч, иргэдээс ирүүлсэн өргөдөлийн дагуу 344 зөрчлийг цахим болон цаасан баримттай тулган иргэний бүртгэлийн мэдээллийн санд засвар өөрчлөлт орууллаа. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн сан /eprs /-д цахимжуулалтын болон, улсын бүртгэгч нараас эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөхдөө алдаа гаргасан 108 бүртгэлийн зөрчлийг; 2025 оны 04 дүгээр сарын 08-ны байдлаар Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан /ERPSv2/-д эрхийн улсын бүртгэл хийсэн огноог ирээдүй цаг дээр алдаатай оруулсан 10 бүртгэлийг; Эд хөрөнгийн мэдээллийн санд талбайн хэмжээний бичвэрт тоо цэгээс өөр тэмдэгт

			бичигдсэн 37 бүртгэлийг шалгаад засвар өөрчлөлтийг хийж гүйцэтгэлээ. Хуулийн этгээдийн бүртгэлийг хөтлөх явцад архив руу шилжүүлэх төлөв буруу сонгосон 9 бүртгэлийг засварлав.
	Гадаад зорчих эрхийн бүртгэлийн талаар	16 нэгжид гадаад паспортын үйлчилгээг нэвтрүүлж 6025 гадаад паспортын захиалгыг бүртгэж иргэдэд олгосон байна. Монгол улс-Оросын Холбооны Улсын хилийг цааш нааш нэг удаа нэвтрэх эрхийн 21137 үнэмлэх олгожээ.	Мандал, Баянгол, Ерөө, Хүдэр Баруунбүрэн, Сант, Орхон, Хушаат, Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг сум, Шаамар сум, Ерөө сумын Бугант, Орхонтуул сумын Рашаант, Мандал сумын Түнхэл, Шаамар сумын Дулаанхаан тосгодод эрхийг нээж 16 нэгжид гадаад паспортын үйлчилгээг нэвтрүүллээ. Монгол Улс-Оросын Холбооны Улсын хилийг цааш нааш нэг удаа нэвтрэх эрхийн үнэмлэхийг анхан шатнаас олгох, ачааллыг тэнцвэржүүлэх, хилийн бүсийн Хүдэр, Түшиг,Цагааннур,Ерөө,Бугант тосгоны улсын бүртгэгчид эрх олгон /10 улсын бүртгэгч/ хөтөлж Монгол Улс-Оросын Холбооны Улсын хилийг цааш нааш нэг удаа нэвтрэх эрхийн 19553 ширхэг үнэмлэх олгосон байна.
	Хүн амын шилжилт хөдөлгөөний талаар:	Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 332 тоот тогтоолоор батлагдсан “Монгол улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэжээ. мэдээлэх журам”-ын дагуу	Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 332 тоот тогтоолоор батлагдсан “Монгол улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам”-ын дагуу аймгийн хэмжээнд: ✓ баг хооронд шилжсэн – 1312 /хүүхэд -607/, ✓ сум хооронд шилжсэн–1537 /хүүхэд -238/, ✓ аймаг, нийслэлээс-1781 /хүүхэд–836/ иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хөтөлж хянан баталгаажуулан ажиллав.
	Хүн амын төрөлтийн өсөлт бууралтын талаар		Иргэний улсын бүртгэлд: ✓ Төрсний 1141

			✓ Үрчилсний 27 ✓ Овог, эцэг /эх/-ийн нэр, нэрээ өөрчилсний 44 ✓ Эцэг/эх/ тогтоосны 67 ✓ Гэрлэсний 257 ✓ Гэрлэлт дуусгавар болсны 108 ✓ Нас барсны 527 ✓ Иргэний үнэмлэхний 3647 ✓ Шилжилт хөдөлгөөний 3318 ✓ Гадаад паспортын 3992 ✓ Регистрийн дугаар өөрчилсний 6 ✓ Лавлагаа 10478 олгожээ. Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсэгт заасны дагуу засаг захиргааны нэгжийн харьяалал харгалзахгүйгээр: ✓ Төрсний 410 ✓ Эцэг /эх/ тогтоосны 08 ✓ Гэрлэсний 100 ✓ Гэрлэлт дуусгавар болсны 38 ✓ Нас барсны 88 ✓ Иргэний үнэмлэхийн 720 ✓ Гадаад паспортын 624 ✓ Лавлагаа 5340 олгожээ.
	Шашны байгууллага, Сүм хийд, Төрийн бус байгууллагын талаар:	2024 оны байдлаар шашны байгууллага буюу 24 сүм хийд улсын бүртгэлд бүртгэлтэй байна.	Аймгийн хэмжээнд 28 сүм хийд үйл ажиллагаа явуулж байгаагаас хугацаа дуусан боловч сунгалтаа хийлгээгүй 8 сүм хийд шашны байгууллага, улсын бүртгэлээс хасагдсан 2, хугацаагүйгээр алдаатай бүртгэгдсэн 4 байна.
	Тагнуулын ерөнхий газрын Сэлэнгэ аймаг дахь газрын 2023 оны 43/51 дугаартай зөвлөмжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр:		Ирүүлсэн зөвлөмжийг хэлтсийн нийт албан хаагчдад танилцуулж, үндэсний аюулгүй байдлыг хангах, гадаад улсын тагнах болон бусад үйл ажиллагаанд өртөх, төрийн болон албаны нууц задруулах, үрэгдүүлэхээс урьдчилан

			сэргийлж, энэ талаар тухай бүр мэдээлэл ирүүлж ажиллах талаар дараах үүргийг өгч ажиллалаа. Хэлтсийн даргын зөвшөөрөл, удирдамжгүйгээр гадаадад албан хэргээр зорчих, арга хэмжээнд оролцох, албан ёсны мэдээлэл, мэдэгдэх, яриа хэлцэл хийхгүй байх, гадаад улсын албаны болон хувийн хэвшлийн төлөөлөлтэй уулзахгүй байх. Үндэсний аюулгүй байдалд хохирол учруулахуйц зүйл ярихгүй байх. Гадаад улсад албан хэргээр зорчих тохиолдолд хэлтсийн даргын зөвшөөрлийг заавал авч, гадаад улсад зорчсон тухай тэмдэглэл, танилцуулгыг нууцын ажилтанд тухай бүр хүргүүлэх. Гадаад улсад хувийн хэргээр зорчих тохиолдолд хэлтсийн нууцын ажилтанд заавал мэдэгдсэн байх эдгээр болно. 2024 онд хувийн шалтгаанаар гадаад улсад зорчсон 4 албан хаагч нууцын баталгаагаа гаргаж мэдүүлэг өгч тайлбараа ирүүлж ажилласан байна.
--	--	--	---

Санал: Аймгийн ИТХ-аас тодорхой үйл ажиллагаа зохион байгуулж Цагдаагийн газар, Тагнуулын байгууллага, Татварын газар, Улсын бүртгэлийн хэлтэс зэрэг эрх бүхийн байгууллагын хамтарсан шалгалт хийж эдгээр сүм хийдийг татан буулгах, эсхүл үйл ажиллагааг зохих ёсоор бүртгэлжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

ТАЙЛАН ГАРГАСАН: СЭЛЭНГЭ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ЗАХИРГААНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
Э.ЗОЛ-ЭРДЭНЭ